



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/222

Ховд

᠒Эрх шилжүүлэн, ажил гүйцэтгүүлэх тухай ᠒

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.2.5 дахь заалт, 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 440 дүгээр тогтоолоор батлагдсан “Зэвсэгт хүчний анги, байгууллага, салбарын тусгай хэрэгцээний газрын хориотой бүс тогтоох журам”-ын 2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар “төсөв батлах тухай” тогтоолын 4.28 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэвсэгт хүчний зэвсэгт хүчний 123 дугаар ангийн батальоны байр, засвар хийх ажлын санхүүжилтийн эрхийг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч /Х.Энхболд/-д шилжүүлсүгэй.

2. Дээрх төсөл арга хэмжээний санхүүлжилтэд зарцуулагдах 80.0 сая /наян сая/ төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.28-д тусгагдсан “Аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, Ардын хувьсгалын 100 жилийн ой угтсан бүтээлч ажил, тохижилт, засвар үйлчилгээ, бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.


3. Төсөл арга хэмжээг 2021 оны 07 дугаар сарын 01-ний дотор багтаан чанартай сайн гүйцэтгүүлэхийг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч

/Х.Энхболд/, аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт үүрэг болгосугай.

4. Эд хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэхийг орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ